

“ЭРХ ЧӨЛӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ”

НАМ

УБ, СБДүүрэг, Шуудангийн 48 –р салбар, хайрцаг- 117

Утас: 95133439, 99113439, 80003439,


E-mail: fredof_mn@yahoo.com,

2016.04.27

УРИА: МОНГОЛЫН ТӨЛӨӨ

ЭЧХН -н Боловсруулан Зөвлөлдөх Хороо

Цетт



ЭЧХН-с 2016 оны УИХ-н ээлжит сонгуульд

хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөр

Үндэсний аюулгүй байдал тусгаар тогтнолоо хамгаалан бэхжүүлж эдийн засгийг гадаад дотоодын олигархиудаас хараат бусаар хөгжүүлэх зорилгоор ЭЧХН-н УИХ-н ээлжит сонгуульд оролцож 2016-2020 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрөө Монгол улсын онцлог, Монгол Улсын үндсэн хууль, Сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль болон УИХ -н 19-р тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал -2030” хууль эрх зүйн орчинд нийцүүлж боловсруулсан болно.

Үүнд:

1. Монгол Улсын эдийн засгийг сэргээн хөгжүүлэхдээ иргэдийнхээ эрүүл мэнд, боловсролын үзүүлэлтийг эрчимтэй дээшлүүлэн, Хүний хөгжилийн индексийг 2020 онд 0.746-аас доошгүй болгох уурь амьсгалыг бүрдүүлнэ. Монгол улсын хөгжлийг удирддаг супер тархитай /өндөр хүчин чадалтай компьютер/ болгож иргэдийнхэрэглээний зээл 1,5 их наядад судалгаа шинжилгээ хийж дүгнэлт гаргана.
2. Сурагчдын дүрэмт хувцасны тендерийг зогсооно. Оюутны төлбөрийг 100% тэглэх эрх зүй орчинг судалж, сургалтын чанарыг олон улсын түвшинд хүргэнэ.
3. Орон сууцны зээлийн хүүг 5 хүртэл хувь болгож урьдчилгаа 30 хувь авахгүй, төрөөс баримталж байгаа орон сууцны зээлийн түрээсийг өмчилөх эрх нь нээгдэх эрх зүйн орчинг судална.

000014

4. Давхар барьцаагүй зээлдэг эрх зүйн орчинг хуульчилж олон улсад мөрддөг зээлийн эрхийн картны эрх зүйн орчинг санаачилж дэс дараалалтай арга хэмжээг авч, мөн түрээслэгч түрээслүүлэгчийн хуулийг боловсронгуй болгоно
5. Үндэсний үйлдвэрлэлийг гурвалсан холбоогоор бодитоор дэмжинэ. Мөн малчдад ноогддог түүхий эдийн урамшууллыг хоршооллоор дамждаг биш шууд эзэндээ хүрдэг эрх зүйг бий болгоно. Эдийн Засгийг эрчимжүүлэх нэмэлт арга хэмжээ авч нэг хүнд ногдох ҮНО-г 8980 америк долларт хүргэх боломж байгааг хэрэгжүүлэхийг эрмэлзнэ. Хүний Хөгжлийн Индексийг 0.746 болгох нөхцөл бүрдүүлэх арга хэмжээ авна.
6. Өмч хувьчлалаар завсардсан иргэдэд тэгшитгэл бий болгох эрх зүйн орчинг санаачилна.
7. НӨАТ-н босго 50 сая хүрээгүй бол бүртгэдэггүй хуулийг хүчингүй болгож, бүх нийтээрээ бүртгэлтэй НӨАТ-г 1% болгох эрх зүй орчинг санаачилна. /хавсралт-1/
8. Замын-Үүдийн хил гаалиар иргэд гадагш зорчих хэсгийн гарцын хүчин чадлыг 100% ашиглаж гадаадад зорчих үйлчилгээг хөнгөн шуурхай болгоно.
9. Төрийн өмчийн оролцоотой компаниудыг ажиллуулж Норвегийн уул уурхайн эрх зүй орчинг Монголын хөрсөнд тохирох эсэхийг судална.
10. Хөдөлгөөнт холбооны үйлчилгээг Монгол улсын нутаг дэсвгэрийн 80-аас доошгүй хувьд, хүн амын 95-иас доошгүй хувьд, интернетийг хүн амын 70-с багагүй хувьд хүргэж иргэд хөдөөд, бэлчээрт хөдөлгөөнд гэдгээсээ үл хамааран, холбоо, интернэтийн үйлчилгээг нийслэлийн үзүүлэлт тарифаар авдаг, орон нутгийн дамжуулахын урсгалыг жил бүр 2-оос доошгүй нэмэгдүүлж 2020 онд 20 дахин нэмэгдүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ. /хавсралт 2-с/
11. Авилгалтай тэмцэх, эрүүгийн хуулинд өөрчлөлт оруулж хууль бусаар олсон, оруулсан орлогыг хурааж, насаар төрийн албанд ажиллах эрхийг хасж гурван үеэрээ төрийн албанд ажиллах эрхийг хориглосон эрх зүйн орчинг бий болгож цаазын ялыг сэргээх асуудлыг судална.

ЭЧХН-н БОЛОВСРУУЛАН ЗӨВЛӨЛДӨХ ХОРОО

ЭЧХН-н

Дарга



Шоовдорын ТӨМӨРСҮХ

000015

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30

2016.04.27 № 737

танай _____-ны № _____-т

Нийцлийн талаарх дүгнэлт

Монгол Улсын Их Хурлын 2016 оны ээлжит сонгуульд оролцохоор бүртгүүлэх хүсэлт гаргаж байгаа Эрх чөлөөг хэрэгжүүлэгч намын "Сонгуулийн мөрийн хөтөлбөр"-т Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хянаж дүгнэлт гаргав.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Улсын Их Хурлын ээлжит сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Сонгуулийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж, хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний санхүүгийн эх үүсвэрийн талаарх тооцоо, судалгааг Төрийн аудитын байгууллагад ирүүлж Сонгуулийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5-д заасны дагуу дүгнэлт гаргуулах хариуцлага хүлээнэ.

Үндэсний аудитын газар Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.17-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд намын боловсруулсан сонгуулийн мөрийн хөтөлбөр Сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуультай нийцэж буй эсэх талаарх дүгнэлтийг Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5-д заасан хугацаанд Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлэх үүрэгтэй.

Дүгнэлтийн үндэслэл


Үндэсний аудитын газар УИХ-ын ээлжит сонгуульд оролцох Эрх чөлөөг хэрэгжүүлэгч намаас ирүүлсэн "Сонгуулийн мөрийн хөтөлбөр"-ийг Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт-4000, Төрийн хяналт шалгалтын стандартыг удирдлага болгон Сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль болон "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030", Монгол Улсын нэгдсэн төсвийн 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2018 оны төсвийн төсөөллийн тухай хуульд нийцүүлэн дүгнэлт гаргав.

Дүгнэлт

Эрх чөлөөг хэрэгжүүлэгч намын Сонгуулийн мөрийн хөтөлбөр нь Сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030", Монгол Улсын нэгдсэн төсвийн 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2018 оны төсвийн төсөөллийн тухай хуультай нийцсэн болно.

Хувийг: Эрх чөлөөг хэрэгжүүлэгч намд

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД